

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙН
ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ЗАРИМ ОНЦЛОГ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор, дэд профессор.

Түлхүүр үг: улс төрийн мэдээлэл, лидер, эрх мэдлийн сэтгүүл зүй, нийгмийн зөвшилцөл.

Улс төрийн сэтгүүл зүйн тухай ярихад хүний мөн чанар болох нийгмийн дэг журам, үнэт зүйл, засаглалын асуудлыг хөндөх болдог. Өөрөөр хэлбэл улс төрийн сэтгүүл зүй нь хүний нийгэм дэх засаглал эрх мэдлийн хүрээний тухай үйл явдал, үзэгдлийн мэдээллийг олон түмэнд түгээх улмаар тэдний санаа бодлыг төлөвшүүлдэг онцлогтой болно. Улс төрийн биеворист хандлагын томоохон төлөөлөгч Вудро Вилсоны "улс төр бие хүний хэмжүүртэй байдаг... улс төрийн үйл байдлын шалтгаан бол хүний өвөрмөц уг чанар бүхий сэтгэл зүйн сэдэл байдаг"¹ зэргээр тэмдэглэсэн нь ч улс төрийн сэтгүүл зүйн нэгэн онцлог болой. Ер нь нийгмийг тэр дундаа улс төрийг хүнээс эхэлж хүнээр төлөвшиж бас хүнээр төгсдөг ертөнц гэдэг. Тиймээс улс төрийн сэтгүүл зүйг бид хүний тухай тэхдээ эрх мэдэл нөлөө засаглал бүхий хүний үзэл бодол үйл ажиллагааны тухай мэдээллийн харилцаа гэж болно. Энд улс төрийн ухааны сэтгэлгээний эрт эдүгээгийн үзэл номлолыг ч нэмэн асуудлын мөн чанарыг тодотгож хүний асуудал чухлыг ярьж болно. Улс төр нь

нийгмийн шудрага байгуулал, дэг журмыг бий болгох төлөвшүүлэх тухай байсан эргэцүүллийн үедээ ч бурханлиг хүн, жолоодогч, эзэн хаантай холбоотой хэмээн үзэж байжээ. Өнөөгийн улс төрийн сэтгүүл зүйд ч лидерийн имиж, нэр хүндийг мэдээллийн домог билэгдлээр бий болгож байна. Социалист нийгмийн үеийн малчин ардын хүүхдээс төрийн жолоодогч болон тодорсон сурталчилгаа, өдгөө цагийн эрдэмтэн зохиолч элитийн бүр хутагт хувилгаадын үр сад мэтээр имижээ төлөвшүүлж буй мэдээллийн довтолгоо нь ч мөн чанарын хувьд төгс хүн, бурханлиг хүмүүний тухай гэдгээрээ адил зүйл юм. Түүнчлэн Платоны "нийгэм-төрийн байгууллын хэв маяг болох полисыг захирах эрх үүргийг зөвхөн мэргэдэд хамааруулж"² байсан үзэл, Аристотелийн "хүн бол улс төрийн амьтан, түүний хамтач ахуйн төгс загвар нь захирагчийн ёс суртахуун, хүнлэг сэтгэлтэй холбож байсан томьёолол"³ зэрэг нь өдгөө ч улс төрийн сэтгүүл зүйн бодит тусгал билээ. Нөгөө талаар улс төрчийн тухай сэтгүүл зүй хэмээн үзэж байгаагийн өөр нэгэн шалтгаан нь олон нийтийн мэдээлэл авах эрэлт хэрэгцээ, түүний нөлөө байр суурьтай холбоотой. Олон нийт хэмээх ойлголт нь бие хүний төлөв

байдал үгүй эрх ашиг, үнэт зүйл, итгэл үнэмшлийн хувьд адил ижил мэт дүрээр ханддаг, адилсал дууриаллаар нөхцөлддөг нийтлэгээр тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл олон нийт нь хүний нийгэмч дүр төрхийн хамгийн сэтгэлзүйжсэн, хөөрсөн, догдолсон, адилссан төлөв байдаг гэсэн үг. Ийм дүр төрхт хүний мэдээллийн эрэлт хэрэгцээ нь ч ердөө сонирхох, харин нөлөө нь нийгэмших буюу бусадтай адил байх, тэгснээр бусдын дунд байх

төдий л төвшинд ойлгогдож байгаа юм. Тиймээс олон нийт нь мэдээллээс өөрсдийнх нь санаа бодолд нийцсэн, хэлнийцсэн, хэрэглээний агуулгыг л эрэлхийлдэг болох нь ээ. Гэхдээ энд мэдээлэл хэрэггүй олон нийт ухамсар дорой хэмээж байгаа юм бий шүү. Сэтгүүл зүй нь хүний нийгэмч, дүр амьдралын хамгийн түгээмэл, хэрэглээний буюу сэтгэл зүйн эрэлт хэрэгцээний үг утга билэгдэл байдаг, уншигч үзэгч улс төрийн үйл явдал үзэгдлийн учир шалтгаан, тайлбар дүгнэлтийг бус, харин зөрчилт, дуулиант, бүр санаанд оромгүй баримт сэлтийг илүү сонирхдог, мэдээллийн нөлөө нь хүний бусадтай ярилцах, үзэл бодлоо илэрхийлэх, хүрээнд байдаг гэсэнд оршиж байна. Тэгээд ч сэтгүүл зүйг нийгэм улс төрийн цаг үеийн аливаа асуудалд хариу дүгнэлт өгдөг бус, харин асуудлыг нь нээн гаргадаг тогтолцоо гэдэг нь ч олон нийтийн мэдээлэл ойлгомжтой энгийн бас

санаа сэтгэлд нь нийцэхүйц байхын учир байгаа юм. Энэ ч утгаараа нийгэм улс төрийн үйл явдал хямрал зөрчлийг лидерээр дамжуулж, түүний алдаа оноо, амжилт ялагдлын загвар, өгүүлэл болгон нийтэлж нэвтрүүлэх нь олон нийтэд илүү сонирхолтой, энгийн, ойлгомжтой болдог байна. Тэгээд ч өмнө өгүүлсэнчлэн олон нийтийн мэдээллийн эрэлт хэрэгцээ нь хүмүүсийн сонирхлын төвшинд байдаг, нөгөө талаар хүнд хүнээс илүү сонирхолтой зүйл

үгүй гэж бодоход улс төрийн сэтгүүл зүйн энгийн үнэн болох хүний сэтгүүл зүй гэдэг нь ойлгогдох байх аа. Тодруулбал эдийн засгийн сэтгүүл зүй мөнгөний тухай байдаг, спортынх ялалт ялагдлынх, харин улс төрийнх нь эрх

«

Олон нийт нь хүний нийгэмч дүр төрхийн хамгийн сэтгэлзүйжсэн, хөөрсөн, догдолсон, адилссан төлөв байдаг гэсэн үг. Ийм дүр төрхт хүний мэдээллийн эрэлт хэрэгцээ нь ч ердөө сонирхох, харин нөлөө нь нийгэмших буюу бусадтай адил байх, тэгснээр бусдын дунд байх төдий л төвшинд ойлгогдож байгаа юм.

»

мэдэл засаглалынх болно.

Улс төрийн сэтгүүл зүйг нийгмийн эрх мэдэл засаглалын сэтгүүл зүй гэж үзэх нь онолын төдийгүй, практик бодит үнэнтэй холбоотой юм. Гэхдээ мэдээж улс төрийн шийдвэр гаргагч хошуучлагчийн тухай байж сая бүрэн дүүрэн болно. Тэгээд ч нэрт философич Никколо Макиавеллийн "хошуучлагчийн нөлөө байр суурийг дэмжих, лидер ба олон нийтийн зэрэг таатай харьцаа ойлголцолын орчинг бүрдүүлэх, эрх мэдэл засаглалаа хамгаалах үлгэр дууриалал үзүүлэх бол улс төрийн засаглалын амин чухал зүйл"⁴ гэсэн учиртай. Нөгөө талаар Италийн сэтгэгч Гаэтано Москагийн "Элит нь засаглалын

үүрэг зорилгод тохирсон номлолыг түгээн дэлгэрүүлэх замаар бусдыг захиран удирддаг"⁵ гэсэн үзэл нь ч улс төрийн сэтгүүл зүйн нийгэм дэх оршихуй юм. Харин үүнийг сэтгүүл зүйн утгаар нь үзвэл олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх хэмээж болно. Олон нийтийн санаа бодол бол нийгэм цаг үедээ хандах хүмүүсийн ухамсар, гэхдээ хандлага сэтгэгдэл зэрэг сэтгэл зүйн агуулгатай ухамсар юм. Тиймээс ч олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлэх, шинэчлэх эрмэлзлэл улс төрчдөд байдаг нь ойлгомжтой. Олон нийтийн санаа бодол ч хувьсамтгай цаг үе, асуудал дагадаг мөртлөө нийгмийн амьдралд бодит нөлөө үзүүлдэг "хүч" юм. Нөгөө талаар орчин үеийн нийгмийн амьдралд олон нийтийн нөлөө байр суурь хүчтэй байгаа нь ч тэдний санаа бодол чухал хүчин зүйл болохыг нотолж байгаа юм. Хэрэглэгчид, сонгогчид, залуус гээд улс төр эдийн засгийн амьдралын гол тоглогчид болж байгааг бид мэднэ. Тэхлээр олон нийтийн санаа бодол нь улс төрчийн ч олон нийтийн ч аль алиных эрх ашиг сонирхлыг тодорхойлогч хүчин зүйл болж таарах нь. Либерал үзэл санааны томоохон төлөөлөгч Джон Локк "Төр хорвоогоос заяагдсан хүний эрхийг хамгаалдаг бол нийгмийн харилцаа (олон нийтийн санаа бодол. зох) бүхнийг захирах гэсэн засаглалын тэмүүллийг чөдөрлөж, засаглал нь дур зоргоороо чөлөөтэй байх гэсэн хүний төрөлх шинжийг намжаан барьж байдаг"⁶ тухай үзэл нь улс төрийн амьдрал дахь олон нийтийн санаа бодлын гүн бат угшил билээ. Чухам ийм засаглалыг хязгаарладаг олон нийтийн санаа бодлыг бий болгох нь улс төрийн сэтгүүл зүйн тэргүүн үүрэг мөн.

Улс төрийн сэтгүүл зүйн мөн чанарыг өнөөгийн нийгэм цаг үетэй холбон тодорхойлох нь сонирхолтой төдийгүй, чухал зүйл юм. XIX зууны сонгодог нийгэм судлалд капитализмыг нийгмийн түгээмэл зүй тогтол хэмээн үзэж байжээ. Үүний бодит жишээ нь Макс Вебер, Карл Маркс нарын дэлхийн нийгмийн хөгжлийн талаархи үзэл сургаал болой. Гэвч өдгөө бид капитализмыг үндэсний, бүс нутгийн, өрнөдийн, дорны хэмээн ойлгож тодорхойлохуйц баримт, дүгнэлтийг нэрлэж болох мэдээлэл, мэдлэгийн төвшинд хүрлээ. Монгол орон монголчуудын хувьд ч өвөрмөц зах зээлийн эдийн засаг, ардчилсан нийгмийн тогтолцоог төлөвшүүлж байна. Нийгмийн аливаа өөрчлөлт нь шинэ нийгэмшил, дүр, үнэт зүйлийг бүтээж байдаг. Энэ ч утгаараа бид өмнөх үед байгаагүй юм уу эсвэл далд үүрэг эрхэмлэлийг онцолж чухалчилж байх жишээтэй. Ийм жишээг ч хэвлэл мэдээллийн амьдралаас харж болно. Гэхдээ энд би ерөнхий дүгнэлт эргэцүүллийн хүрээнд асуудлыг томъёолж байна.

Юуны өмнө бид нийгмийн өөрчлөлт шинэчлэлт хийгээд арав гаруй жилийг үзэж буй баримт байна. Гэвч нийгэм улс төрийн амьдрал, харилцаа тэр бүү хэл мэдээллийн утга, билэгдэл, хэв маяг хуучин хэвээр байна. Өөрөөр хэлбэл нийгэм цаг үеийн орчин нөхцөл өөрчлөгдсөн ч хүмүүсийн сэтгэхүй тэр дундаа сэтгүүл зүй үл өөрчлөгдсөн байх жишээтэй. Үүнийг би коммунист агуулгатай капиталист хэлбэртэй сэтгүүл зүй хэмээн томъёолж байна. Нийгэм, эдийн засагт гарч буй эрс өөрчлөлтийг үл анзаарагч сэтгүүл зүй гэж байна. Манай сэтгүүл зүйд үзэл сурталжсан, магтсан эсвэл ардын дайсан болгодог хандлага оршоор

байна. Энд би манай улс төрийн сэтгүүл зүй нь нийгэм цаг үеийн бодит дүр төрхийг "улс төрийн цонх"-оор харж чадахгүй байна хэмээн шүүмжилж буй юм. Тиймээс ч улс төрийн сэтгүүл зүй "лидер—шийдвэр—үйл явдал—нийгэм" гэсэн гурвалсан хүчин зүйлийн хүрээний мэдээллийн харилцаа байж чадахгүй байгаа юм.

Өөр нэгэн манай улс төрийн сэтгүүл зүйн асуудал нь мэдээллийн хуучин тогтолцоо устаж, үзэл суртлын хэрэгсэл, зохион байгуулагч

үүрэг зорилго нь нийгмийн байгуулалтад нийцэхээ больсон явдал юм. Тэгээд ч дээдлэгч эрхэмлэгч байр суурьтай байсан улс төрийн сэтгүүл зүй нь үл итгэгч, төөрөгдүүлэгч болон ойлгогдох болсон. Нөгөө талаар мэдээллийн хэрэгсэл хоорондын нэгдмэл тогтолцооны орчин эвдэрч,

телевиз нь улс үндэстний агуулгатай мэдээллийг төрийн хяналт дор түгээж байхад сонин нь нийгмийн асуудлыг илүү онцолж, бас хувийн хэвшил давамгайлж байгаагаараа ялгаатай байх жишээтэй. Нөгөө талаас улс төрийнхөн мэдээллийг хянах эрмэлзлэлтэй байхад хэвлэл мэдээллийнхэн эрх чөлөөг дээдэлж, олон нийт нь төрөөр тэтгүүлэх, төрд бүхнээ даатгах сэтгэхүйн шүүлтүүрээр мэдээллийн үнэлэмж, байр сууриа тодорхойлсоор ирэв. Өөрөөр хэлбэл бөмбөг ганц байхад нэг нь волейбол, нөгөө нь хөл бөмбөг, гуравдахь нь гандбол тоглож байна гэсэн үг. Чухамдаа энд л улс төрийн

сэтгүүл зүйн хямрал оршиж байна. Учир нь улс төрийн сэтгүүл зүй нь лидер болоод олон нийтийн хоорондын эрх ашиг сонирхлын нэгдмэл байдал, ойлголцол, зөвшилцөл, бас ёс зүйн гүүр байх үүргээ гүйцэтгэж чадахгүй байгаа юм. Ер нь улс төр нийгмийн дэг журам, ёс суртахууны үнэт зүйлд тулгуурлаж байж сая мөн чанараа хадгалж байдаг гэдэг. Тэгвэл ийм мэдээллийн орчин үгүй тохиолдолд улс төрийн сэтгүүл зүй төөрөх нь ойлгомжтой.

Улс төрийн сэтгүүл зүйн өөр

нэгэн хямрал нь улс төрийн шинэ үнэт зүйлийг төлөвшүүлж чадахгүй байгаад оршино. Нийгэм-эдийн засаг, цаашилбал эрх зүйн орчинд бий болсон бодит өөрчлөлтийн улс төрийн тайлбар дүгнэлт, хэтийн төлөвийн тухай агуулга үгүйлэгдсээр байна. Энэ нь дээд төвшин-

«

Улс төрийн сэтгүүл зүйн өөр нэгэн хямрал нь улс төрийн шинэ үнэт зүйлийг төлөвшүүлж чадахгүй байгаад оршино. Нийгэм эдийн засаг цаашилбал эрх зүйн орчинд бий болсон бодит өөрчлөлтийн улс төрийн тайлбар дүгнэлт, хэтийн төлөвийн тухай агуулга үгүйлэгдсээр байна.

»

дээ нэгэнт шинэчлэгдсэн элитийн хүрээний байр суурь, шинж төлвийг өөрчлөх сонирхол үгүй, хамгаалах эрмэлзлэлтэй болсон, харин доод буюу олон нийтийн дунд өөрчлөлтөөс эмээх хандлага, идэвхгүй байдал бий болсны үр дагавар юм. Нэг үгээр сэтгүүл зүй дамжуулагч, түгээгч төдий үүргийг улс төрийн бүхий л орчинд гүйцэтгэх болжээ. Энэ нь нийгэм улс төрийн элитийг олон нийтийн санаа бодолд хүлээн зөвшөөрүүлэх ингэснээр үнэт зүйл, үзэл бодлын хувьд нэгдмэл хандлагыг бий болгох улмаар жинхэнэ харилцаа байх сэтгүүл зүйн хөгжлийн таатай орчинг үгүйсгэж

байгаа юм. Тэгээд ч бидний улс төрийн мэдээллийн орчин асуудлыг нээн гаргаж, нийгмээр шийдвэрлүүлэх бус харин сарниулах, үгүйсгэх талдаа буй нь хямралын шалтгаан болоод байна. Эдүгээчлэл, шинэчлэлийн талаас хэвлэл мэдээлэл нь нийгмийн хөгжлийн санаа сэтгэхүйн хөдөлгүүр байх атал харин чиг хоосрол, үл ойлголцлын галыг асааж байгаа нь өнөөгийн улс төрийн сэтгүүл зүйн нэгэн тулгамдсан асуудал болж байна.

Эцэст нь тэмдэглэхэд улс төрийн сэтгүүл зүй нь улс төрийн засаглалын нөөц болох нийгэм хүний үнэт зүйлийг төлөвшүүлж байдаг төдийгүй, түүнийг бий болгогч арга хэрэгсэл болдогынхоо хувьд зайлшгүй шинэчлэх асуудал болсоор байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Америкийн их сэтгэгч А.Тоффлер "хэн мэдлэг мэдээллийг эзэмшиж байна түүнд засаглал эрх мэдэл оршино"⁷ хэмээсэн нь улс төрд ч, сэтгүүл зүйд ч адил хамаарах номлол болно. Тиймээс ч бид улс төрийн сэтгүүл зүйг зүй зохист байдлаар нь бүтээн босгох цаг болжээ.

Ишлэл

- 1 Улс төрийн шинжлэх ухаан. (Ер. ред. Ц.Ганболд). УБ. 2001. Х. 24.
- 2 Мөн зох. Х. 39.
- 3 Мөн зох. Х. 40.
- 4 Мөн зох. Х. 48.

- 5 Мөн зох. Х. 56.
- 6 Мөн зох. Х. 51.
- 7 Тоффлер А. Шок от бъдещето. София. 1992. С. 187.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- 1 2001. Улс төрийн шинжлэх ухаан. (Ер. ред. Ц.Ганболд). УБ.
- 2 Арентс Э. 1994. Човекът — социално животно. София.
- 3 1997. Введение в политологию. Под ред. В.П.Пугачёва. М.
- 4 Маккуейл Д. 1993. Масова комуникация. София.
- 5 Меррилл Дж., Маккуейл Д. 1998. Беседа о масс-медиа. М.
- 6 Тоффлер А. Шок от бъдещето. София. 1992.
- 7 Graber A. 1994. Media Power in Politics. N.-Y.

Резюме

В данной статье автор высказывает свое мнение о том, что политическая журналистика есть целенаправленная деятельность по распространению информации о власти и власти имущих, конечной целью которой является оказывание влияния на аудиторию. Одна из особенностей политической журналистики заключается в формировании общественного мнения. По мнению автора, кризис современной монгольской политической журналистики состоит в том, что СМИ беспомощны создать единство ценности и идей, заставить массы признать политическую элиту и т.д.